



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2016 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 4/415

Улаанбаатар хот

**Баримт бичгийн урсгалыг нэгдсэн зохион
байгуулалтад шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Архивын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.1, Мэдээллийн ил тод байдлыг ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 15 дүгээр зүйлийн 15.2, 15.3, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 141 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас үзүүлж байгаа үйлчилгээг "Хурдан, талц, нээлттэй" хүргэх зорилгоор иргэн, байгууллага, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдол, албан бичгийг зөвхөн Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвөөр хүлээн авч, харну өгч ажиллахыг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.

2. Төрийн байгууллагуудын хоорондын үйл ажиллагаатай холбоотой албан бичгийг ангилж, төрийн албан хэрэг зөвлөлтийн үндсэн зааврын дагуу хүлээн авч нэгдсэн бүртгэлд төвлөрүүлэн шийдвэрлэхийг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Баримт бичгийн урсгалыг нэгдсэн зохион байгуулалтад шилжүүлэхтэй холбогдуулан шаардлагатай арга хэмжээг авч, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нутгийн захиргааны удирдлагын хэлтэс /У.Ганболд/, тоон гарын үсэг, цахим баримт бичгийн солилцоог нэвтрүүлэх асуудлыг шуурхай зохион байгуулж, хэрэгжүүлэхийг нийслэлийн Архивын газар /С.Гавал/, нийслэлийн Мэдээллийн технологийн газар /Б.Бат-Өлзийт/ тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд элналт тавьж ажиллахыг нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Е.Гаралнулуун/-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГ
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАЛ



Э.БАТ-ҮҮЛ